



ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 12 сарын 04 өдөр

Дугаар А/707

Сайншанд сум

Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цагийн хязгаарт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 74 дүгээр зүйлийн 74.1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсэг, 68 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудаас гарсан саналын дагуу аймгийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн А/774 дүгээр захирамжийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан согтууруулах ундаа худалдах цагийн хязгаарт дор дурдсанаар өөрчлөлт оруулсугай.

№	Тусгай зөвшөөрлийн төрөл	Цагийн хязгаар
1	2	3
1	Согтууруулах ундаа худалдах	07:00-00:00
2	Согтууруулах ундаагаар үйлчлэх	11:00-22:00
3		14:00-02:00

2.Хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж, цагийн хязгаарыг мөрдөж ажиллахыг тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагын захирал, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (Б.Батзориг), аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ж.Наранболд), сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн өөрчлөлтийг холбогдох хууль, журмын дагуу захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (Ч.Нандин-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О.БАТЖАРГАЛ

